



НИГҮҮЛСЭЛ

Тойм мэдээлэл

“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО” УУЛЗАЛТАД 115 ХҮН ОРОЛЦЛОО

Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг тохиолдуулан Архангай, Булган, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Увс, Ховд, Хөвсгөл аймагт “Гамшгийн эрсдэлийг бууруулахад эмэгтэйчүүдийн оролцоо” уулзалт семинар зохион байгуулав. Семинарт Монголын улаан загалмай нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Болормаа, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Т.Баярчимэг, Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн удирдлагын газрын ажилтан П.Амарзаяа, Б.Дуламсүрэн нар оролцож, мэдээлэл хийсэн юм. Семинарт нийт 115 хүн оролцлоо.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөр

10.13
CAPМОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ
НИЙГЭМЛЭГ

"Санхүүжилтийг
гамшгийн үед
зарцуулахаас
илүү даван
туулах чадавхыг
бэхжүүлэхэд
чиглүүлье"



ЦӨӨН МӨР

- ☒ Хамтын ажиллагааны хүрээнд **Өнөр бүл** хүүхдийн төвд Анхны тусламжийн танхим тохижуулж, хүлээлгэн өглөө.
- ☒ Олон улсын Харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах **“Цагаан таягтны өдөр”** өдрөөр **20** харааны бэрхшээлтэй иргэнийг кино үзүүлж, соёлын арга хэмжээнд хамруулав.
- ☒ Ажлын байранд анхны тусламж үзүүлэх дадал, чадварыг эзэмшүүлэх сургалтад **268** хүн хамрагдав.
- ☒ Байгууллагын фэйсбүүк хуудсанд нийт **43** мэдээ, мэдээлэл нийтэлж, **296,257** хүнд хүрсэн байна.



НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭГДЭВ

Монголын улаан загалмай нийгэмлэгийн Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын газраас Олон улсын Шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран "Нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгийн үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтыг 10 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Хүүхэд залуучуудын хөгжлийн төвд зохион байгууллаа.

Сургалтыг "Уур амьсгалаас үүдэлтэй гамшигт тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд хөдөө орон нутгийн иргэд, ялангуяа эмзэг нөхцөлд байгаа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд чиглэсэн мэдээлэл, дэмжлэг, нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд зохион байгуулсан юм.

Төсөл Хөвсгөл, Завхан, Төв, Сүхбаатар аймагт хэрэгжиж байгаа бөгөөд орон нутгийн Дунд шатны хороодын аргазүйч, сайн дурын идэвхтнүүд оролцов.

Энэхүү сургалт нь нийгэм сэтгэл зүйн дэмжлэгийг өөрөө удирдан зохион байгуулах, зорилтот бүлгийн иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэдлэг, чадвартай олгох чиглэлээр оролцогчдын чадавхжуулах юм.

Сургагч багшаар бэлтгэгдсэн оролцогчид орон нутагтаа нийгэм сэтгэл зүйн чиглэлээр олон нийтэд сургалт зохион байгуулах, мэдлэг ойлголт өгөх, шаардлагатай тохиолдолд орон нутгийн шуурхай штабт дэмжлэг үзүүлэн ажиллана.




ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТ ХИЙЛЭЭ



Монголын улаан загалмай нийгэмлэг Австралийн улаан загалмайн байгууллагатай хамтран ажиллах дунд хугацааны төлөвлөлт хийлээ. Тодруулбал, Австралийн улаан загалмайн төлөөлөгчид 10 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд Монголын улаан загалмай нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн даргын газарт ажилласан юм.

Хоёр байгууллагын хамтын ажиллагааны стратегийн хүрээнд дунд хугацааны төлөвлөлт хийж, ирэх 5 жилийн үйл ажиллагааны ерөнхий зураглалаа боловсруулав.

Энэ үеэр 2025 оны 06-09 дүгээр сард зохион байгуулсан Монголын улаан загалмай нийгэмлэгийн “Хамгаалал, жендэр, оролцооны бодлого”-ын хэрэгжилтийн хөндлөнгийн судалгааны үр дүнг танилцуулж, цаашид хэрэгжүүлэх зөвлөмжийг хэлэлцэв. Мөн Ази Номхон далайн бүсийн хэмжээнд энэхүү үнэлгээг амжилттай хэрэгжүүлсэн 2 дахь Үндэсний нийгэмлэг болсныг онцлов.



“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслийн хүрээнд Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймгийн **8** сумын бэлтгэгдсэн **80** сайн дурын идэвхтэн талбарын судалгаа хийж, уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн үеийн бэлэн байдлын талаарх мэдлэг, ойлголт, дадал хэвшлийг малчдад ойлгуулах, уур амьсгалын өөрчлөлтөд илүү үр дүнтэй дасан зохицоход нь шаардлагатай нэн чухал дэмжлэгийг тодорхойлоход чиглэсэн судалгааны асуумжийг **600** хүнээс авч, мэдээлэл цуглуулав.



Дунд шатны хороодын дунд иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх, даван туулах чадавхыг сайжруулах сургалт сурталчилгааны ажлын төрөл, бүтээмж, хүртээмжийг нэмэгдүүлэх, бүтээлч байдлыг дээшлүүлэх зорилгоор уралдаан зарласан юм. Уралдаанд **Өмнөговь аймгийн Дунд шатны хороо 1 дүгээр байр, Сонгинохайрхан дүүргийн Дунд шатны хороо 2 дугаар байр, Говь-Алтай аймгийн Дунд шатны хороо 3 дугаар байр, Сүхбаатар, Завхан аймгийн Дунд шатны хороо шагналт байр** эзэлсэн юм.

“Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал” сэдэвт гэр бүл, хүүхэд хамгааллын нээлттэй өдөрлөгийг Монголын сайн дурынхны төвтэй хамтран, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэмжлэгтэйгээр зохион байгуулав. Өдөрлөгийн хүрээнд хүүхдийн хөгжил, хамгааллын олон талт асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, туршлага хуваалцах боломжийг бүрдүүлэн, багш нарын оролцоо, манлайллыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Өдөрлөгт нийт **100 сургуулийн багш, нийгмийн ажилтан** хамрагдав.



Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй **“PROTECT PROJECT”** төслийн хүрээнд Хүүхэд, залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн баг **“Зөв сонголт-Зөв амьдрал”** нөлөөллийн аяныг зохион байгуулав. Аянд нийт **314** хүүхэд хамрагдсан байна.

Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудын дунд **“Хүмүүнлэгийн байгууллагуудын спортын нөхөрсөг”** тоглолт тэмцээнийг зохион байгуулав.



АЛДАРШУУЛАХ

БУЛАН



Монгол орны өнцөг булан бүрт хүмүүнлэгийн үйл ажиллагаа хурдан шуурхай, тэгш, хүртээмжтэй хүргэхэд хамгийн чухал үүрэгтэй хүмүүс бол сайн дурын идэвхнүүд юм.

Нигүүлсэл сэтгүүл **“Алдаршуулах булан”**-даа Өмнөговь аймгийн Улаан загалмайн хорооны Сайн дурын идэвхтэн Хүүхнээгийн Мөнхнасанг онцолж байна.

Тэрбээр цэцэрлэгийн багш мэргэжилтэй. 2018 онд сайн дурын идэвхтнээр элсэж, багачуудын улаан загалмайн багшаар өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

Энэ хугацаанд **200** гаруй хүүхэд багачуудын улаан загалмайч болгож, хүнлэг, энэрэнгүй ёсыг түгээн дэлгэрүүлж, харж хандах хүнгүй **7** ахмадад **32** удаагийн гэрийн эргэлт хийж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж ирсэн туршлагатай сайн дурын идэвхтэн юм.

Х.Мөнхнасан **“Сайн дурын ажил хийхээр бусдад өгөхийн сайхныг мэдэрдэг. Их зүйл өгөхдөө биш, тусламж хэрэгтэй хүнд тусалснаар би өөрөө сэтгэл дүүрэн явдаг. Хэн нэгний төлөө нэгдсэн сайхан сэтгэлтэй олон хүмүүсийн дунд ажиллах хамгийн гоё. Ялангуяа хүүхэд багачууд, ахмадуудтай ажиллах хамгийн сайхан”** хэмээн сайн дурын идэвхтэн хийж байх үеийн сэтгэгдлээ хуваалцсан юм.

Хүмүүнлэг үйлсийн төлөө хамтдаа!



ОЛОН УЛСЫН УЛААН ЗАГАЛМАЙ, УЛААН ХАВИРГАН САР ХӨДӨЛГӨӨНИЙ ҮНДСЭН 7 ЗАРЧИМ

БИДНИЙ ДАГАЖ МӨРДӨХ ЗАРЧИМ



ЭНЭРЭНГҮЙ БАЙХ Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар хөдөлгөөний хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь тулалдааны талбарт шархдагсдад ялгаварлалгүйгээр тусламж үзүүлэх, олон улсын болон үндэсний хэмжээнд хаана ч болов хүнийг зовлон зүдгүүрээс урьдчилан сэргийлэх, хуваалцан хөнгөвчлөх чин хүслээр туслах явдал юм. Түүний зорилго нь хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүнийг хүн ёсоор хүндэтгэх явдлыг хангуулахад оршино. Хөдөлгөөн нь хүмүүсийн хоорондын харилцан ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагаа болон урт хугацаанд энх тайван байдлыг хөхиүлэн дэмжинэ.



ШУДАРГА БАЙХ Нийгэмлэг нь хүнийг яс үндэс, арьс өнгө, шашин шүтлэг, нийгмийн давхарга, улс төрийн үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй. Хувь хүний зовлонг нимгэлж, гагцхүү тэдний хэрэгцээнд тулгуурлах бөгөөд хамгийн хүнд нөхцөлд байгаа хүмүүст эн тэргүүнд анхаарал тавина.



ТӨВИЙГ САХИХ Олны итгэл найдварыг хүлээхийн тулд Хөдөлгөөн нь сэргөлдсөн талуудын аль нэг талыг баримтлахгүй байх бөгөөд ямар ч үед улс төр, арьс өнгө, шашин, үзэл бодлын шинж чанартай сэргөлдөөнд орж болохгүй.



БИЕ ДААХ Хөдөлгөөн нь бие даасан байна. Үндэсний нийгэмлэг нь өөрийн улсын төр засгийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд нэмэлт хүч болж, улсын хууль тогтоомжид захирагдахын зэрэгцээ ямар ч үед Хөдөлгөөний зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулж байхын тулд өөрсдийн бие даасан байдлыг ямагт хангаж байх ёстой.



САЙН ДУРЫН БАЙХ Нийгэмлэг нь тусламж үзүүлэх зорилготой сайн дурын хөдөлгөөн бөгөөд ямар ч үед ашиг олохыг эрмэлзэх ёсгүй.



НЭГДМЭЛ БАЙХ Аливаа улсад нэг л Улаан загалмай эсхүл Улаан хавирган сар нийгэмлэг байна. Энэ нь бүх нийтэд нээлттэй байх ба хүмүүнлэгийн үйл ажиллагааг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулна.



ТҮГЭЭМЭЛ БАЙХ Олон улсын Улаан загалмай болон Улаан хавирган сар хөдөлгөөнд аливаа нийгэмлэг бүр тэгш эрхтэй байх ба бие биедээ харилцан туслах талаар адил үүрэг, хариуцлага хүлээдгээрээ дэлхийд түгээмэл шинжтэй байна.